

**ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ САЛБАРЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨРИЙН II ДАХЬ ҮЕ ШАТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨ /2021-2022 ОН/ 2022 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

№	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа
	1.	2.	3.
Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр.			
1.		Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох	“Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг” гаргах эрх бүхий 1 албан хаагч ХАСУМ гарган өгч хянуулан төрийн жинхэнэ албан хаагчаар томилоод байна.
2.	4.1.1.1. Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх	Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг(ХАСУМ)-ийг гаргах, хянах үйл ажиллагааг цахимаар хэрэгжүүлж ажиллах	Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн https://meduuleg.iaac.mn/ -д системд цахимаар мэдүүлгээ 2022 оны 01 сарын 27-ноос 2 сарын 05-ны хооронд бөглөн Аймгийн Хууль эрх зүйн хэлтсээр хянуулж, баталгаажуулан Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.
3.		Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох	Орхон аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 2022 оны 04 сарын 05-ны өдрийн 135 дугаар албан бичгээр 3 сул орон тоо, 2022 оны 09 сарын 19-ны өдрийн 400 дугаар албан бичгээр 1 сул орон тооны захиалга өгч төрийн албаны www.csc.gov.mn цахим хуудсанд, байгууллагын www.erdenetgazar.mn цахим хуудсанд сул орон тооны мэдээг иргэд олон нийтэд түгээсэн. Захиалгын дагуу шалгалт зохион байгуулагдсан. Шалгалтын дагуу 2 албан хаагчийг томилсон.
4.	4.1.1.2.Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг,	Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд сул орон тооны захиалгыг хүргүүлсэн.

	боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх.	чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх	
5.	4.1.1.6. нийтийн албаны ёс зүйн үлгэрчилсэн дүрмийг батлах, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг хэвшүүлэх	Байгууллагын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод нээлттэй болгох	Газрын даргын 2019 оны А/09 дүгээр тушаалаар байгууллагын “Ёс зүйн зөвлөл”-ийг байгуулан, дүрмийг баталсан. 2022 онд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Ёс зүйн зөвлөлийг чадавхжуулах” сэдэвт сургалтад Ёс зүйн зөвлөлийн гишүүн Д.Жавхлантагс хамрагдсан. 2022 онд Төрийн албан хаагчидтай холбоотой ёс зүйн зөрчил, гомдол гараагүй байна.
6.	4.1.1.9.Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл, боломжийг сайжруулах	Төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, цахимжуулан мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх. Үүнд: Байгаль, орчин аялал жуулчлалын яам, Ашигт малтмал газрын тосны газар Улсын бүртгэлийн ерөнхий газар Нотариатчдын холбоо	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2017 оны 04 сарын 06-ны өдрийн А/103 дугаар “Програм хангамж ашиглах тухай” тушаалыг хэрэгжүүлэн байгууллагын удирдлагын системийн “Эйбл” програм хангамж мөн аймгийн Засаг даргын 2016-2020 оны Үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд мэдээллийн технологийг ашиглан байгууллагуудыг холбох и-оффис системийг 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс нэвтрүүлэн байгууллагын албан хэрэг хөтлөлтөд тус тус ашиглаж байна. Өргөдөл гомдол болон орон нутгийн төрийн байгууллагуудаас ирсэн бичгийн бүртгэлийг и-оффис системд бүртгэж, Барилга хот байгуулалтын яам, ГЗБГЗЗГ болон Барилгын хөгжлийн төвөөс “эйбл” программаар ирүүлсэн албан бичгийг тухай бүр удирдлагад танилцуулан цохолт хийлгэн хуваарилуулж, мэргэжилтнүүдэд шилжүүлэн, хугацаатай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Тайлант хугацаа хүртэл нийт 1635 өргөдөл хүсэлт ирснээс 1631 өргөдөл хүсэлтэд хариу хүргүүлэн ажилласан байна. Засаг даргаас 57 шуурхай үүрэг даалгавар ирсэн ба цаг алдалгүй шийдвэрлэж хаах тал дээр анхаарч ажиллаж байна.
7.	4.1.1.10.Нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан	Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах. Үүнд:	Авлигатай тэмцэх газраас 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 09:00 цагаас зохион байгуулсан “Авлига ашиг

	тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх	Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын албан хаагчдыг сургах Үндэсний форумын оролцогчдыг авлигын эсрэг сургалтад хамруулах	сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон мэдэгдэл тайлбарыг хэрхэн гаргах талаарх” цахим сургалтад Газрын дарга Д.Цолмон, Газрын удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Болдбаатар, Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга Г.Буянхүү, Барилгын хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Цэцэгээ нар хамрагдсан. Албан хаагчдад зориулсан сургалтыг мөн өдрийн 14:00 цагт зохион байгуулсан бөгөөд сургалтад Кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Бүрэн-Эрдэнэ, Газрын даамал С.Даваасүрэн, Геодези зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн А.Содномпил, Газар зохион байгуулалт, төлөвлөлт, өмчлөлийн асуудал хариуцсан мэргэжилтэн У.Анхнысүвд, Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн О.Дүүрэнжаргал нарын нийт 9 ажилтан албан хаагч хамрагдсан.
Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр.			
8.	4.1.2.1.төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх	Орон зайн суурь 16 төрлийн өгөгдөл солилцох “Нэг газрын зураг”, “Нээлттэй газрын зураг” үйлчилгээг нэвтрүүлэх, Салбарын тусгай зөвшөөрөл болон мэргэжлийн байгууллагын эрх олгох үйл ажиллагааг цахимжуулах, Бүх шатны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд ирүүлсэн иргэд олон нийтийн саналд анализ хийж хариу өгөх модулыг хөгжүүлэх, Геодези, зураг зүйн бүтээгдэхүүн, үйлчилгээг цахимжуулах, цахим үйлчилгээ үзүүлэх	Байгууллагын албан ёсны мэдээллийн 4800 гаруй дагагчтай олон нийтийн www.facebook.com/erdenetgazar цахим сүлжээгээр байгууллагын болон, Барилгын хөгжлийн төв, АЗДТГ, ГЗБГЗЗГазраас салбарын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг олон нийтийн цахим сүлжээгээр сурталчлан 92 мэдээллийг хүргэн 18685 хандалт авсан байна
9.	4.1.2.7.төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах	Салбарын системүүдийн мэдээллийн аюулгүй байдалд аудит болон эрсдэлийн үнэлгээ хийлгэх	Аймгийн засаг даргын 2020 оны 02 сарын 03-ний өдрийн А/54 тоот захирамжаар “Барилга хүлээж авах улсын комисс”-ын бүрэлдэхүүнийг баталсан бөгөөд бүрэлдэхүүнд Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэний холбооны төлөөлөгч Ц.Мөнх-Эрдэнийг тогтмол оролцуулж хөндлөнгийн хяналт хийлгэж байна. Орхон аймагт 2022 онд нийт 34 барилга байгууламжид ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон ба 13

			барилга байгууламжид улсын комисс ажиллаж ашиглалтад оруулсан.
Дөрөв. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр			
10.	4.1.4.3. Худалдан авах ажиллагааны бодлого төлөвлөлтийг сайжруулж, ил тод болгох, олон нийтээр хэлэлцүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх	“Цахим худалдан авах ажиллагаа”-ны нэгдсэн системд мэдээллээ бүрэн оруулах, тогтмол ажиллагааг хангаж, худалдан авах ажиллагааг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулах	Байхгүй.
Долоо. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах чиглэлээр.			
11.	4.1.7.3.Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх.	Төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэн, шилэн дансны бүртгэлийг тогтмол хөтлөх	Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын мэдээллийг хуулийн хугацаанд оруулан, тайлагнаж байна. Шилэн дансны сайтад үйл ажиллагаа, худалдан авалт, хүний нөөц, төсөв санхүүгийн нийт 20 үзүүлэлтийг сар, улирал, хагас бүтэн жилээр байршуулдаг бөгөөд үүнээс төсөв санхүүгийн 9 үзүүлэлтийг сар бүр шинэчлэн, зохих хугацаанд нь байршуулан ажилласан.
Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр			
12.	4.1.10.1.авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор аж ахуй нэгжид сурталчилгааны ажлыг зохион байгуулах	Байгууллагын 4800 гаруй дагагчтай Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын www.erdenet.gazar.gov.mn цахим хуудсанд Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн зурагт хуудсыг байршуулан иргэд олон нийтэд хүргэсэн.
13.	4.1.10.1.авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	Газрын харилцааны салбарын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийн үр дүнг шинжилгээ хийж тайлагнах	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2022 оны А/25 дугаар тушаалаар баталсан “Газрын харилцааны салбарын 2022 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г байгууллагадаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Хагас, бүтэн жилийн хэрэгжилтийн тайлан ХЭЗХ болон ГЗБГЗЗГ-т цахимаар болон цаасаар хүргүүлсэн.

